

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 06 дугаар сарын 29 ны өдрийн
1346 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо "Амин тус" өрхийн эрүүл мэндийн төв

№	Эд хөрөнгийн нэр	А/ жил	Хэмжих нэгж	Тоо/х	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Автоклав	16	ш	1	246,386.00	246,386.00	246,386.00	-	Ашиглах боломжгүй	актлах	актлах	татах
2	Компьютер	11	ш	1	960,687.00	960,687.00	960,687.00	-	Ашиглах боломжгүй	актлах	актлах	татах
3	Компьютер	11	ш	1	720,000.00	720,000.00	720,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	актлах	татах
Тоног төхөөрөмжийн дүн				3	1,927,073.00	1,927,073.00	1,927,073.00	-				
1	Хивс	12	ш	1	150,000.00	150,000.00	150,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	актлах	татах
2	Үзлэгийн ор	17	ш	1	237,341.00	237,341.00	237,341.00	-	Ашиглах боломжгүй	актлах	актлах	татах
3	Энгийн ор	9	ш	1	180,000.00	180,000.00	180,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	актлах	татах
4	Сурагч ширээ	18	ш	3	27,135.00	81,405.00	81,405.00	-	Ашиглах боломжгүй	актлах	актлах	татах
Тавилга эд хогшлын дүн				6	594,476.00	648,746.00	648,746.00	-				
Нийт данснаас хасах хөрөнгийн					9	2,521,549.00	2,575,819.00	2,575,819.00				
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө						2,575,819.00						
Актлах хөрөнгө												



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар В/346

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн “Амин тус” өрхийн
эрүүл мэндийн төвийн эргэлтийн
бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,575,819.0/хоёр сая таван зуун далан таван мянга найман зуун арван есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн “Амин тус” өрхийн эрүүл мэндийн төв /Д.Туул/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 4 нэр төрлийн нийт 2,575,819.0 /хоёр сая таван зуун далан таван мянга найман зуун арван есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн “Амин тус” өрхийн эрүүл мэндийн төв /Д.Туул/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000767